

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ А.ДИНА ТАНАА

2024.02.14 № 101
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402148

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,550,041.00	169,907,036.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,534,091.00	146,565,146.30
31211	Төрийн сангийн харилцах	28,534,091.00	146,565,146.30
35	БАРАА МАТЕРИАЛ	23,015,950.00	23,341,890.00
35410	Бичиг хэргийн материал	1,182,300.00	1,182,300.00
35420	Аж ахуйн материал	4,080,140.00	9,454,740.00
35460	Хүнсний материал	886,850.00	338,190.00
35470	Бусад хангамжийн материал	16,866,660.00	12,366,660.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	670,892,651.66	672,663,415.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	670,892,651.66	672,663,415.70
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	626,505,651.66	626,985,176.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	641,070,210.00	661,070,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,429,700.16)	(77,944,625.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,838,900.00	58,128,990.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,652,120.38)	(38,819,899.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,528,605.00	45,653,605.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,850,242.80)	(21,103,103.52)
393	Биет бус хөрөнгө	44,387,000.00	45,678,239.00
39301	Програм хангамж	660,000.00	2,083,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(528,000.00)	(660,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,255,000.00	44,255,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	722,442,692.66	842,570,452.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	722,442,692.66	842,570,452.00
51	Засгийн газрын хувь оролцоо	722,442,692.66	842,570,452.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,255,000.00	44,255,000.00
51101	Өмч: - төрийн	44,255,000.00	44,255,000.00
51102	- хувийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	395,688,356.46	515,816,115.80
51210	Өмнөх үеийн үр дүн	395,688,356.46	395,688,356.46
51220	Тайлант үеийн үр дүн	-	120,127,759.34
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	282,499,336.20	282,499,336.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	722,442,692.66	842,570,452.00

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	434,663,300.00	667,953,239.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		- 30,579,139.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		- 29,704,139.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		- 875,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	389,265,900.00	600,034,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,293,900.00	37,340,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,293,900.00	37,340,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	435,695,670.78	547,825,479.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,695,670.78	547,825,479.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,493,081.78	547,825,479.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,321,058.00	332,154,391.70
210101	Үндсэн цалин	233,880,879.00	281,558,505.24
210102	Нэмэгдэл	41,847,288.00	39,562,530.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-
210104	Урамшуулал	4,592,891.00	11,033,355.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,566,513.00	64,650,135.00
210201	Тэтгэврийн даатгал	28,144,031.00	50,544,210.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,605,571.00	3,561,475.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,284,540.00	2,714,186.00
210204	Ажилгүйдлийн даатгал	321,132.00	707,295.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,211,239.00	7,122,969.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,787,644.00	36,840,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,837,944.00	5,600,000.00
210302	Түлш, халаалт	16,440,000.00	30,440,000.00

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	509,700.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
2105	Нормативт зардал	56,279,119.00	71,691,703.00
210502	Хоол, хүнс	56,279,119.00	67,191,703.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		- 4,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	450,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,000.00	1,243,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	758,000.00	1,243,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,226,447.78	40,745,549.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,202,882.00	7,997,931.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	2,680,054.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,523,565.78	30,067,564.96
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,202,589.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,202,589.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,032,370.78)	120,127,759.34
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,032,370.78)	120,127,759.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	434,663,300.00	637,374,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	389,265,900.00	600,034,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	389,265,900.00	600,034,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,293,900.00	37,340,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,293,900.00	37,340,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	405,689,209.00	517,208,854.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,689,209.00	517,208,854.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,486,620.00	517,208,854.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,850,719.00	352,374,628.70
210101	Үндсэн цалин	247,875,971.00	301,778,742.24
210102	Нэмэгдэл	26,030,724.00	39,562,530.92

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	3,944,024.00	11,033,355.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,036,852.00	44,429,898.00
210201	Тэтгэврийн даатгал	25,185,067.00	30,323,973.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,962,795.00	3,561,475.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,370,556.00	2,714,186.00
210204	Ажилгүйдлийн даатгал	592,438.00	707,295.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,925,996.00	7,122,969.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,787,644.00	36,840,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,837,944.00	5,600,000.00
210302	Түлш, халаалт	16,440,000.00	30,440,000.00
210303	Цэвэр, бохир ус	509,700.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	
2105	Нормативт зардал	55,796,223.00	66,643,043.00
210502	Хоол, хүнс	55,796,223.00	66,643,043.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	450,800.00	500,000.00
210604	Урсгал засвар	450,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,000.00	1,243,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	758,000.00	1,243,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,702,882.00	15,177,585.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,202,882.00	12,497,531.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	2,680,054.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,202,589.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,202,589.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,974,091.00	120,165,245.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	440,000.00	2,134,190.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	440,000.00	2,134,190.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(440,000.00)	(2,134,190.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,534,091.00	118,031,055.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		28,534,091.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,534,091.00	146,565,146.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	395,688,356.46		722,442,692.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	395,688,356.46	0.00	722,442,692.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	395,688,356.46	0.00	722,442,692.66
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	395,688,356.46	0.00	722,442,692.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	395,688,356.46	0.00	722,442,692.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			120,127,759.34		120,127,759.34
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,255,000.00	282,499,336.20	515,816,115.80	0.00	842,570,452.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	665,904,200.00	519,343,044.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,904,200.00	519,343,044.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,904,200.00	519,343,044.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,592,700.00	352,374,628.70
210101	Үндсэн цалин	321,788,600.00	301,778,742.24
210102	Нэмэгдэл	143,718,200.00	39,562,530.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	13,085,900.00	11,033,355.54
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,214,600.00	44,429,898.00
210201	Тэтгэврийн даатгал	40,265,600.00	30,323,973.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,737,300.00	3,561,475.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,790,000.00	2,714,186.00
210204	Ажилгүйдлийн даатгал	947,400.00	707,295.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,474,300.00	7,122,969.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,840,000.00	36,840,000.00
210301	Гэрэл, цахилгаан		

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

		5,600,000.00	5,600,000.00
210302	Түлш, халаалт	30,440,000.00	30,440,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
2105	Нормативт зардал	71,448,000.00	66,643,043.00
210502	Хоол, хүнс	71,448,000.00	66,643,043.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,243,700.00	1,243,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,243,700.00	1,243,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,065,200.00	17,311,775.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,334,000.00	13,872,721.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,731,200.00	3,439,054.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	637,374,100.00	637,374,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	600,034,100.00	600,034,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	600,034,100.00	600,034,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,340,000.00	37,340,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,340,000.00	37,340,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		28,534,091.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		146,565,146.30
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн тэгш эрхийг хүндэтгэн хангаж, авьяас сонирхол, хүүхэд төвт арга зүй технологи зохион байгуулалтын дагуу эрүүл чийрэг, эерэг зан төлөвтэй суралцах, чадвартай хүүхэд болгон хөгжүүлэх, хүүхэд нэг бүрд чиглэсэн сургалт үйл ажиллагааг явуулах, үр дүнг тооцож, сурах хөгжихөд тохирсон орчныг бүрдүүлэн ажиллах, цэцэрлэгийн насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газар, аймгийн санхүү хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118.4 сая төгрөгөөр буюу 329.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28534.1	146565.1	118031.0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	23015.9	23341.9	326.0
Үндсэн хөрөнгө	670892.7	672663.4	1770.7
Нийт хөрөнгө	722442.7	842570.5	120127.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	722442.7	842570.5	120127.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	722442.7	842570.5	120127.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 146.6 сая төгрөг болж оны эхнээс 118.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 141.0 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 0.8 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал, 4.8 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 23.3 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Хүнсний материал 0.3 сая, аж ахуйн материал 9.5 сая, бичиг хэргийн материал 1.2 сая, бусад хангамжийн материал 12.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө 30.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 30.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 842.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 120.1 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 556.8 сая, орон нутгийн төсвөөс 37.3 сая, нийт зарлагыг 594.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 507.2 сая төгрөгөөр хянаж, 49.6 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 92.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 600.0 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 37.3 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 600.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 37.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 637.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 600.0 сая, орон нутгийн төсвөөс 37.3 сая нийтдээ 637.3 сая төгрөгийн санхүүжилт авч 28.5 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519.3 сая төгрөг буюу 78 хувьтай буюу дансанд 146.6 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	1865.6	1470.5	395.1	78.8%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	71448.0	66643.0	4805.0	93.2%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3886.6	3886.6	0	100%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1865.6	1865.6	0	100%
5	81834	Боловсролын стандарт, сургалтын	404948.3	311923.2	93025.1	77%
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	144550.1	96214.1	48336.0	66.6%
7	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	37340.0	37340.0	0	100%
Нийт дүн			665904.2	519343.0	146561.2	78%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 146.6 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ.Үүнд: цалингийн зардал 126.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 14.8 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.8 сая, хүүхдийн хоолны зардал 4.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 77.3 сая төгрөгийн бараа материал, 2.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 435.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 8.3 сая төгрөгийн 23 шийдвэр, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 119.8 сая төгрөгийн 7 удаагийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 64.3 хувьтай гарсан зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд зөрчлийг арилгасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	128,100.0	1	128,100.0	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	128,100.0	1	128,100.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 8.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 8.7 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	8,740.0					1	8,740.0				
Дүн	1	8,740.0					1	8,740.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								